



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/429

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "г", 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдаж авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6, 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсгүүд, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын лабораторын өргөтгөлийн барилгын зураг төсвийн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай урьдчилгаа төлбөр болох 15000000 (Арван таван сая) төгрөгийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын гэрээгээр өгөх санхүүжилтээс тооцон захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд)-д даалгасугай.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, удирдлага зохицуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД